


## Цацрагийн түвшний 2024 оны 07 сарын төлөв


Завхан аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн Улиастай сумын Улиастай-01, Баянтэс сумын Баян-уул өртөөдөд **RDS-110** багажаар тус тус цацрагийн түвшний хэмжилтийг өдөр бүр 08 болон 14 цагуудад тогтмол хэмжилт хийж байна.

07 дугаар сарын хэмжилтийн дүнгээс харахад: Цацрагийн түвшний хамгийн их утга 0.14 микрозиверт/цаг, бага утга нь 0.08 микрозиверт/цаг байна.

Улиастай, Баянтэс сумдын 07 сарын агаар болон газрын гадарга дах цацрагийн түвшний тунгийн чадлын өдрийн дундаж утгийг графикаар харуулав.




**График 1.** Улиастай сумын агаар болон газрын гадарга дах цацрагийн түвшний тунгийн чадлын өдрийн дундаж утга



**График 2.** Баянтэс сумын агаар болон газрын гадарга дах цацрагийн түвшний тунгийн чадлын өдрийн дундаж утга


\*Улиастай өртөөний цацрагийн түвшний тунгийн чадлыг өмнөх оны мөн сартай харьцуулан дараах графикаар харуулав.



**График3.** Улиастай сумын 2023, 2024 оны цацрагийн хэмжилтийн утга

Хэмжилтийн дүнгээс харахад 2023 онд агаар дах цацрагийн түвшний дунджийн хамгийн их утга нь 0.12 микрозиверт/цаг, хамгийн бага утга нь 0.10 микрозиверт/цаг байсан бол 2024 онд дунджийн хамгийн их утга нь 0.12 микрозиверт/цаг, хамгийн бага утга нь 0.10 микрозиверт/цаг байна. Мөн 2023 онд газрын гадарга дах цацрагийн түвшний дунджийн хамгийн их утга нь 0.12 микрозиверт/цаг, хамгийн бага нь 0.09 микрозиверт/цаг байсан бол 2024 онд дунджийн хамгийн их утга нь 0.13 микрозиверт/цаг, хамгийн бага утга нь 0.10 микрозиверт/цаг байна.

\*Баянтэс сумын Баян-Уул өртөөний цацрагийн түвшний тунгийн чадлын дундаж утгыг өмнөх оны мөн сартай харьцуулан дараах графикаар харуулав.



**График4.** Баянтэс сумын 2023, 2024 оны цацрагийн хэмжилтийн утга

Хэмжилтийн дүнгээс авч үзвэл 2023 онд агаар дах цацрагийн түвшний дунджийн хамгийн их утга нь 0.12 микрозиверт/цаг, хамгийн бага утга нь 0.10 микрозиверт/цаг байсан бол 2024 онд дунджийн хамгийн их утга нь 0.12 микрозиверт/цаг, хамгийн бага утга нь 0.09 микрозиверт/цаг байна. Мөн хэмжилтийн дүнгээс харвал 2023 онд газрын гадарга дах цацрагийн түвшний дунджийн хамгийн их утга нь 0.12 микрозиверт/цаг, хамгийн бага нь 0.10 микрозиверт/цаг байсан бол 2024 онд дунджийн хамгийн их утга нь 0.12 микрозиверт/цаг, хамгийн бага утга нь 0.09 микрозиверт/цаг байна.

Дэлгэрэнгүй мэдээллийг <https://www.eic.mn/radiation/> мэдээллийн сангаас харах боломжтой.